



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг сэргээх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Роялкашимер ХААБ” ХХК, “Увс таван эрдэнийн ундарга ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 5 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 371 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтыг чанд биелүүлж ажиллахыг үүрэг болгож, цаашид зөрчил давтан гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхийг “Роялкашимер ХААБ” ХХК, “Увс таван эрдэнийн ундарга ХААБ” ХХК-ийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН